



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/108

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын цахим үйл ажиллагааг дэмжих зорилгоор дотоод сүлжээний хурдыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмжүүдийг шинэчлэхэд 2 950 000 төгрөгийн зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 950 000 төгрөг /Хоёр сая есөн зуун тавин мянган/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.13-д заасан хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
02 дугаар сарын 23-ны өдрийн  
А/108 дугаар захирамжийн хавсралт



“ЦАХИМ ХОВД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДОТООД СҮЛЖЭЭНИЙ  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СОЛИХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| Д.д | Зардлын төрөл  | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ-НӨАТ-тэй /төгрөг/ | Дүн /мян.төг/ |
|-----|--|-------------|------------|----------------------------------|---------------|
| 1.  | Дотоод сүлжээний удирдлагын чиглүүлэгч төхөөрөмж /TL-R600VPN router/       | ш           | 1          | 440 000                          | 440.0         |
| 2.  | Дотоод сүлжээний удирдлагын чиглүүлэгч төхөөрөмж /tp-link tl-e6020 router/ | ш           | 1          | 605 000                          | 605.0         |
| 3.  | Дотоод сүлжээ хувиарлагч төхөөрөмж /Switch 8 port TL-SG1008D/              | ш           | 4          | 77.000                           | 308.0         |
| 4.  | Дотоод сүлжээ хувиарлагч төхөөрөмж /Tenda TEG1024D 101000M/                | ш           | 4          | 253.0                            | 1 012.0       |
| 5.  | Цахим цаг бүртгэлийн төхөөрөмж /ZTK ECO IFACE-702/                         | ш           | 1          | 585.0                            | 585.0         |
| ДҮН |  |             |            |                                  | 2 950.0       |

-oOo-